

**Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Сумын төвийн камержуулалтын  
ажил”-ыг хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл**

2021-07-23

Хараат

**Хуралд оролцсон:**

Зөвлөлийн дарга: -Б.Азжаргал (Хэсгийн төлөөлөгч)

Гишүүд: -Б.Цэндмаа (Санхүү албаны дарга)

-Ж.Чулуунтогтох (Төрийн сангийн мэргэжилтэн)

- З.Батсайхан (ЗДТГ-ын сантехникч) нар оролцож хурлыг  
14 цаг 20 минутанд эхлэв. Архив бичиг хэргийн эрхлэгч Г.Эрдэнэтуяа чөлөөтэй  
ирээгүй учир 4 гишүүнтэйгээр хурлыг үргэлжлүүлэв.

**Хэлэлцсэн асуудал:**

1. Сумын төвийн камержуулалтын ажлыг хүлээн авах.

**Хэлэлцсэн нь:**

**Комиссын дарга Б.Азжаргал:** Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 22- ны өдрийн А/28 тоот тушаалаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Сумын төвийн камержуулалтын ажлыг хүлээн авах комисс байгуулагдсаны дагуу та бүхнийг цуглуулаад байна. Камержуулалтын ажил бүрэн хийгдэж сумын төвд нийт 7 камер суурилуулан, камерийн дэлгэцийг хэсгийн төлөөлөгч миний албан өрөөнд байршуулсантай бүгд танилцаж, камерын хүчин чадал, бусад шаардлагатай зүйлстэй бүгд дэлгэрэнгүй танилцлаа гэж бодож байна. Комиссын гишүүд танилцуулсан зүйлстэй холбоотой саналаа хэлээд асууж тодруулах зүйл байвал асууж тодруулаад саналаа солилцоод явъя.

**Ж.Чулуунтогтох:** Камерын нягтрал болон татах хүчин чадал давгүй юм байна. Багтаамж сайтай, бичлэг хадгалах хугацаа боломжийн юм байна.

**Б.Цэндмаа:** Камерын нягтрал болон хүчин чадлын хувьд Чулуунтогтохтой ижил саналтай байна. Мөн нэмж хэлэхэд камерын байршил оновчтой зөв газар байршуулсан байна гэж үзэж байна. Шаардлагатай бол камерын харах хэсгийг өөрчилж болохоор юм байна гэж бодож байна.

**З.Батсайхан:** Сумын төвийн камержуулалтын ажлыг хүлээн авахад татгалзах зүйлгүй, та бүгдийн хэлсэн, ярьсантай санал нэг байна.